


## Тоос

**12**



**Ажлын байрыг хэчинээн сайжруулсан ч үйлдвэрт яагаад тоос байсаар байна вэ?**

Бутлах, зүлгэх, савлах, оёх, гараар ажиллах, мөн төмөр, хуванцар, даавуу, арьс болон бусад материалыг тайрах, боловсруулахад их хэмжээний тоос, тоосонцор бий болдог. Энэ нь маш жижиг ширхэгтэй тоосонцор байдаг учраас ам, хамар болон арьсанд маш амархан нэвтэрч ордог. Арьс, үс, хувцас, гутлаар дамжин гэрт хүргэл очдог.

Тоос бий болохоос урьдчилан сэргийлэх нь тоосноос болж хохирол учруулахгүй байлгах шилдэг арга юм. Тоос бий болох бүрт арилгаж байх нь түүнтэй тэмцэх сайн арга юм. Тоос нь агаарт болон тоног төхөөрөмжид хуримтлагдаж эхлэх юм бол аюул дагуулна.

Үйлдвэрт хэтэрхий их тоос байгааг илтгэх зарим шинж тэмдэг:

- Ажилчид амьсгаадан шуухитнах эсвэл амьсгалаад хүндрэлтэй байх;
- Ажилчид ханиаж, найтаах мөн ойр ойрхон нусаа нийх;
- Ажилчдын хамарт байгаа нусны өнгө нь ажлын байрны тоосны өнгөтэй болох;
- Тааз, багаж хэрэгсэл, гэрэл, цонх, хана нь тоосоор бурхэгдэх;
- Үйлдвэрийн агаар манантах

## Иоландагийн хөх царай

Иоланда Мексикийн Пиедрас Неграс дахь жийнсний үйлдвэрт ажилладаг. Өдөр бүр ажилчид гэртээ харихдаа жинсний цэнхэр тоосонд хучигдсан байдал байв. Тэдний цаасан амны хаалт нь тоосноос муу хамгаалж, харин дээврийн сэнс нь тоос дэгдээнэ. “Хэрэв гаднаа ингэж бүрхэгдэж байгаа юм бол дотроо ямар харагдах бол?” гэж Иоланда бодлоо.

Үйлдвэрчний эвлэлийн уулзалтын үеэр асуудал хэрхэн ноцтой байгааг үзүүлэхийн тулд нэг өдөр нүүрнээсээ тоосоо арчихгүй байхаар ажилчидтай тохиролцлоо. Өдрийн цайны үеэр тэд бүхэлдээ хөх тоосонд хучигдсан байлаа. Бусад ажилчид Иоландатай хамт менежер рүү явав. Иоландагийн хөх нүүр менежерийг тэвдүүлсэн юм.



Менежер даргаасаа агааржуулалтын сэнс суулгахыг асуусанд зөвшөөрсөн юм. Дарга нь тун дургүй байсан боловч хэрэв байцаагч үүнийг олж мэдвэл тэр эвгүй асуудалд орохоо мэдэж байв. Тиймээс нэг долоо хоногийн дотор сэнс хийхийг зөвшөөрөв. Түүнийг хэлснээ хийхгүй байх үед нь эмэгтэйчүүд шахан шаардаж байв. Ингээд эцэст нь бүх тоног төхөөрөмж сорогч сэнстэй болов.

## Тоосны аюул

Үйлдвэрийн тоосонцор нь ихэвчлэн үйлдвэрлэлд ажилчдын ашиглаж байгаа материалын нарийн жижиг ширхгүүд байдаг. Үйлдвэрийн тоосонд мөн шатсан түлиш эсвэл халуун ба түлэгдсэн материалын хөө тортог агуулагдаж байдаг. Тортогт мөн үйлдвэрлэлийн үед ашиглагдсан химийн бодисын агууламж байдаг.

Тоосноос шалтгаалдаг хамгийн түгээмэл эрүүл мэндийн асуудал нь амьсгалын өвчлөл юм. Зарим тоос хоолой, хамар болон уушгийг цочроох эсвэл харшил, астма өвчинөөр өвдөх шалтгаан болдог. Бусад тоос нь хамраар дамжин уушгийг гэмтээдэг. Даавууны тоос нь хувцасны үйлдвэрт их түгээмэл байдаг төдийгүй энэ нь нэн аюултай уушгины өвчин үүсгэдэг ба үүнийг биссиноз буюу хөвөнгийн тоос залгиснаас үүсэх уушгины өвчин гэдэг. (141-143 дугаар хуудсыг үзнэ үү)

Тоосноос болж уушги нь цочирсон ажилчид ихэвчлэн сурьеэтэй болох магадлал өндөр байдаг. (31-р бүлгийг үзнэ үү)

Тоос нь амьсалахад хүндрэлтэй болгохоос гадна зүрхний saat албай болгодог. Тоос мөн нүд болон арьсны загатнаа үүсгэж, цочроодог.

### Тоос дэлбэрч болно

Би Фоксконнын өнгөлгөөний үйлдвэрт ажилладаг байв. Бидний ажил нь Apple компанийн iPad бүтээгдэхүүний арын хөнгөн цагааныг зүлгэх явдал байсан юм. Үйлдвэр 24 цаг тасралтгүй ажилладаг ба бид өдөр бүр илүү цагаар ажилладаг байсан. Бид ээлжээ дуусах үед битүү хөнгөн цагааны тоосонцорт хучигдсан байдал байлаа: бидний үс, гар, цамц гутлын дотор тал, бүх юм саарал.

Нэг өглөө өнгөлгөөний хэсэгт хүчтэй том дэлбэрэлт болсон. Бүгд л орилж, хашхиран гүйлдэж байв. Бид юу дэлбэрсний ч мэдэхгүй байлаа. Олон хүн гэмтэж, 2 хүн нас барсан байлаа. Хэдэн өдрийн дараа үйлдвэрийг хаасан юм. Тэд мөрдөн шалгалт явуулах болно гэж хэлсэн. Үйлдвэр дахин нээгдэх үед тэд хэлэхдээ тоос татан сорогч нь бүх тоосыг татахгүй болсон байна гэв. Гэвч асуудал нь зөвхөн ганц хоолойд биш, тэнд үргэлж л их хэмжээний тоос байдгийг хүн бүр мэдэж байв. Тэнд нэгээр ч тогтохгүй хэд хэдэн тоос татагч, сорогч ажилладаггүй байв. Үнэндээ тоос хэт хуримтлагдсаар эцэстээ дэлбэрсэн байсан юм.

Хэдэн сарын дараа мөн л iPad-ны арын өнгөлгөө хийдэг өөр нэгэн үйлдвэрт дэлбэрэлт болсон юм. Асуудал нь мөн л адил байв.

(ургэлжлэл)

Үүний дараа Apple компанийнхан бүх ханган нийлүүлэгчдийнхээ агааржуулалтын системийг засссан, дахиж дэлбэрэлт болохгүй гэж хэлсэн юм. Энэ нь үнэн эсэхийг бид харах болно. Дэлбэрэлтээс болж нас барах эсвэл над шиг зөвхөн дэлбэрэлтийн талаар хар дарсан зүйтгэй болж аврагдах эсэхийг бид харах болно.

## Ажилчдыг тоосноос хамгаалах

Ажилчдыг тоосноос хамгаалах шилдэг арга нь тоос үүссэн даруй эх үүсвэрээс тоосыг арилгаж, агаарыг цэвэр байлгах явдал юм.

## Агааржуулалтын систем хэрэглэх

Сайн агааржуулалтын систем нь агаараас тоосыг сорон авч үйлдвэр болон ажилчдыг цэвэр, шинэ агаараар хангаж байдаг юм. Ажилчид ч бага тоосоор амьсгалж, тоног төхөөрөмж болон бусад талбайд тоос бага хурумтлагдах болно. Өөр өөр төрлийн агааржуулалтын системийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 17-р бүлгийг үзнэ үү.



**Суурилуулсан тоос татагч нь үүссэн тоосыг арилгана.**

## Тоосыг цэвэрлэх

Тоосыг цэвэрлэх тогтмол хуваарьтай байснаар шал, тоног төхөөрөмжид тоос хурумтагдааас урьдчилан сэргийлнэ. Цэвэрлэгээ хийх үед хүрэхэд хэцүү хэсгүүд, гэрлийн дээд хэсэг, сэнсний ирнүүд, өндөр цонхнууд зэргийг хамруулах хэрэгтэй. Тогтмол цэвэрлэгээ хийснээр тоос тогтоохгүй ба дахин тоосонд хутгалдахгүй.

Нойтон даавуу, шүүр эсвэл зориулалтын тоос сорогч ашигла. Хэрэв танд цэвэрлэгээ хийхэд зөвхөн шүүр л байгаа бол эхлээд шалан дээгүүр ус шүршиж, дараа нь зөөлөн шүүрд.

Даралттай агаар болон тоос үлээгчээр ажлын байр, тоног төхөөрөмж, шал эсвэл ажлын хувцсыг цэвэрлэж болохгүй. Ингэснээр тоосыг зүгээр л агаарт дэгдээж, түүгээр ажилчид буцаан амьсгалдаг



**Цэвэрлэгээ хийснээр дахин тоостой холилдох асуудал үүсэхгүй болгох хэрэгтэй.**

юм. Даралттай агаар нь мөн тоосонцрыг ажилтны нүүр, нүд рүү үлээж гэмтэл учруулах шалтгаан болдог.

## **Тоостой үед нүүрээ маскаар хамгаалах**

Тоосны маск нь таны хамар, аманд тоос орохоос урьдчилан сэргийлнэ. Гэвч энэ нь агаарт байгаа химийн бодисын уур эсвэл утаанаас хамгаалахгүй юм. 18-р бүлэг Хувийн хамгаалах хэрэгсэл хэсгээс маск, шүүлтүүрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.



**Маск таны нүүрэнд тохирч байгааг баталгаажуул**